



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 11 өдөр

Дугаар А/503

Булган сум

Аялал жуулчлалын тоглолт,  
эвент үйл ажиллагааны техник, тоног төхөөрөмжийн  
түрээс, салютын зардалд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аялал жуулчлалыг хөгжүүлэх, дотоод болон гадаад жуулчдын сонирхлыг татах, иргэд, хүүхэд, залуучуудын идэвхтэй оролцоог дэмжих эвент үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах техник, тоног төхөөрөмжийн түрээс болон баярын салютын зардлыг хавсралтаар баталсугай.

2. Эвент үйл ажиллагааны урлагийн тоглолт, соёл урлагийн арга хэмжээг шинэлэг, бүтээлч байдлаар зохион байгуулахыг Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга (Г.Алдармөнх), үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар ханган, хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг) нарт үүрэг болгосугай.

3. Шаардагдах зардлын 15,621,200 (арван таван сая зургаан зуун хорин нэгэн мянга хоёр зуу) төгрөгийг Аймгийн Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн Булган аймаг, “Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчийн үйлдвэрийн газрын 2025 онд хамтран ажиллах төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010673

Аймгийн Засаг даргын 2025 оны  
07 дугаар сарын 11-ны/ний өдрийн  
А/503 дугаар захирамжийн хавсралт

Эвент үйл ажиллагааны урлагийн тоглолтын техник,  
тоног төхөөрөмжийн түрээс болон баярын салютын төсөв

Д/д	Зардлын нэр	Нийт үнэ
1	2	3
1	Техник, тоног төхөөрөмж түрээс	10,726,200
2	Салют	4,495,000
3	Салют тээвэрлэх зардал	400,000
	<b>Нийт үнэ</b>	<b>15,621,200</b>